



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дүгээр сарын  
...-ний өдөр

Улаанбаатар хот

### БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь байгалийн ургамал, түүний олон янз байдлыг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл.Байгалийн ургамлын тухай хууль тогтоомж

2.1.Байгалийн ургамлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгалийн нөөц ашигласаны төлбөрийн тухай, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### 3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“байгалийн ургамал” гэж байгаль дээр өөрийн түүхэн хөгжлийн зүй тогтлын дагуу ургаж байгаа дээд, доод ургамлыг;

3.1.2.“байгалийн ургамлын түүхий эд” гэж үйлдвэрлэл, аж ахуй, ахуйн хэрэгцээнд зориулан авч хэрэглэх тодорхой зүйл ургамлын газрын дээрх болон доорх хэсэг болох үндэс, үндэслэг иш, булцуу, иш, найлзуур, нахиа, навч, цэцэг, жимс, үр, цэцгийн дэлбэ, цоморлиг, тоос, үрийн идээ, ишний гол, анхдагч болон хоёрдогч шүүс, давирхай мөн тэдгээртэй адилтгах бусад бүрэлдэхүүн хэсгийг ойлгоно;

3.1.3.“биологийн нөөц” гэж тухайн зүйл ургамлын нийт тархац нутагтаа үүсгэж буй биомассын тоо хэмжээ;

3.1.4.“ашиглалтын нөөц” гэж тухайн газар нутгийн хувьд ашиглах ургамлын түүхий эдийн биологийн нөөцийн 20 хүртэлх хувийг;

3.1.5.“байгалийн ургамлын тархац, нөөцийн судалгаа” гэж тухайн зүйл ургамлын тархац нутаг, биологийн болон ашиглалтын нөөцийг тогтоох зорилгоор хийгдэж байгаа судалгааг;

3.1.6.“байгалийн ургамлыг нөхөн сэргээх” гэж хүний буруутай үйл ажиллагаа, байгалийн гамшгийн болзошгүй аюулын үр дүнд үүсэх ургамлын төрөл зүйл, бүлгэмдлийн нөөцийн бүрэн болон хэсэгчилсэн хомсдолоос сэргийлж тэдгээрийн тоон болон чанарын үзүүлэлтийг хэвийн түвшинд бий болгоход чиглэсэн цогц үйл ажиллагааг;

3.1.7.“тарималжуулсан байгалийн ургамал” гэж зориудаар тарьж ургуулсан байгалийн ургамал тэдгээрийн үр, суулгацыг;

3.1.8.“байгалийн ургамлыг тарималжуулах” гэж байгалийн зүйл ургамлыг уугуул тархац нутагт болон экологи орчны ижил төстэй өөр газар нутагт тарималжуулан түүхий эд болгон ашиглах, үржүүлж олшруулах, тарьж ургуулах замаар нэмэгдүүлсэн нөөц бий болгох үйл ажиллагааг;

3.1.9.“ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээ” гэж батлагдсан аргачлалын дагуу тухайн зүйл ургамлын оршин амьдрах нөхцөл болон экологийн, эдийн засгийн, эрх зүйн, нийгмийн ач холбогдлоор нь үнэлсэн нэгж жингийн мөнгөн үнэлгээг;

3.1.10.“байгалийн ургамлын генобанк” гэж Монгол улсын нутаг дэвсгэрт бүртгэгдсэн байгалийн гуурст дээд ургамал, замаг, мөөг, хаг, хөвдийн бүх зүйлийн баримтжуулсан биет материалын хатаамал /гербари/, амьд ургамал, өсгөвөр, үр үрцэрийн цуглуулгаас бүрдсэн сан хөмрөгийг;

3.1.11.“харь ургамал” гэж улсын хилийн гаднаас зориудаар болон санамсаргүй байдлаар зөөвөрлөгдөн ирж нутагшсан болон нутагшуулж байгаа зүйл ургамлыг;

3.1.12.“байгалийн ургамлыг хамгаалах” гэж тэдгээрийн генетик материал, эс, эд, төрөл зүйл, удмын санг бүлгэмдэл, экосистемийн түвшинд тархац нутаг, байгалийн болон зохиомол орчинд хадгалах, хамгаалалтанд авах, тарималжуулах, олшруулах үйл ажиллагааг;

3.1.13.“зөвшөөрөл” гэж ургамлын зүйлийг тарьмалжуулах, ашиглах, түүж бэлтгэх, импортлох, экспотлох болон дээрх үйл ажиллагаанд зохих төлбөр тогтоон иргэн хуулийн этгээдэд төрийн захиргааны байгууллагаас олгох албан ёсны баримт бичгийг;

3.1.14.“байгалийн ургамлын хамтын менежментийн нөхөрлөл” гэж нутгийн иргэдэд байгалийн ургамлыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх эрхийг олгож, нөөц ашиглалтыг хамтаараа, ил тод, шударга зарчимд нийцүүлэн зохион байгуулж, түүнээс гарсан үр ашгийг иргэдэд тэнцүү хуваарилах зорилготой нөхөрлөлийг.

#### **4 дүгээр зүйл. Байгалийн ургамлын ангилал**

4.1.Ургамлыг түүний нөөц, нөхөн сэргэх чадварыг нь харгалзан дараахь байдлаар ангилна:

4.1.1/нэн ховор;

4.1.2/ховор;

4.1.3/элбэг.

4.2.Нэн ховор ургамалд байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, устаж байгаа /энэ хуулийн хавсралтаар тогтоосон/ ургамал хамаарна.

4.3.Ховор ургамалд байгалийн жамаар нөхөн сэргэх чадвар хязгаарлагдмал, тархац, нөөц багатай, устаж болзошгүй эмзэг ургамал хамаарна. Ховор ургамлын жагсаалтыг Засгийн газар батална.

4.4.Энэ зүйлийн 4.1.1, 4.1.2 дэх хэсэгт зааснаас бусад ургамлыг элбэг ургамалд тооцно.

**5 дугаар зүйл. Байгалийн ургамлыг хамгаалах үйл ажиллагааны удирдлага**

5.1.Ургамлыг хамгаалах үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалтын эрх зүйн үндсийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

**6 дугаар зүйл. Байгалийн ургамлын мэдээллийн сан**

6.1.Байгалийн ургамлын мэдээллийн сан дараахь үзүүлэлтээс бүрдэнэ:

6.1.1.байгалийн ургамлын олон янз байдлын;

6.1.2.байгалийн ургамлын цуглуулгын ;

6.1.3.байгалийн ургамал хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний мэдээ;

6.2.Байгалийн ургамлын мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ  
БАЙГАЛИЙН УРГАМЛЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ**

**7 дугаар зүйл. Байгалийн ургамлыг хамгаалах**

7.1.Байгалийн ургамлыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээний хөтөлбөрийг бүх шатны Засаг дарга тухай шатны иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж нутаг дэвсгэртээ хэрэгжилтийг нь зохион байгуулна.

7.2.Байгалийн ургамлыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээний хөтөлбөр нь ургамлын төрөл зүйлийн нөөцийг хадгалах, хойч үедээ өвлүүлэх, эдийн засаг, тогтвортой санхүүгийн механизмыг тусгасан байна.

7.3.Бүх шатны Засаг дарга ургамал хамгааллын арга хэмжээний хөтөлбөрийг батлуулахдаа байгалийн ургамал, түүний нөөцийг бүртгэх, тоолох, хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх шинжлэх ухааны суурь мэдлэгийг үндэслэн тогтооно.

7.4. Ургамлыг гал түймэр, өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьж болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах ажлыг бүх шатны Засаг дарга улсын төсвийн

хөрөнгөөр, гэрээний дагуу газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ.

7.5. Ургамлыг өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавьжаас хамгаалахад байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид \*төрийн захиргааны төв байгууллага\* гэх/-ын зөвшөөрснөөс бусад химийн бодис хэрэглэхийг хориглоно.

7.6. Нэн ховор ургамал бүхий газрыг тухайн ургамалыг хамгаалах, нөхөн сэргээхээс бусад зориулалтаар аливаа этгээдэд эзэмшүүлэхийг хориглоно.

7.7. Нэн ховор, ховор, унаган, завсрын унаган болон үлдвэр ургамлын удмын санг хадгалан хамгаалах зорилгоор ургамлыг амьд хэлбэрээр шинжлэх ухааны байгууллагын дэргэд хадгална.

7.8. Монгол улсын нутаг дэвсгэрт бүртгэгдсэн байгалийн гуурст дээд ургамал, замаг, мөөг, хаг, хөвдийн бүх зүйлийн баримтжуулсан биет материалын хатаамал /гербари/, өсгөвөр, үр үрцэрийн цуглуулгыг генобанканд хадгална;

7.9. Харь зүйл ургамлыг байгальд тарьж ургуулахыг хориглоно.

## **8 дугаар зүйл. Ургамлын тархац, нөөцийн судалгаа явуулах, экологи-эдийн засгийн үнэлгээ тогтоох**

8.1. Ашиглалтанд өртөмтгий ургамлын тархац, нөөцийн судалгааг 5 жил тутамд төрийн захиргааны төв байгууллага, шинжлэх ухааны байгууллагатай хамтран явуулна.

8.2. Ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээг төрийн захиргааны төв байгууллагын баталсан тусгай аргачлалаар байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлана.

8.3. Ургамлын тархац, нөөцийн судалгаа явуулах, экологи-эдийн засгийн үнэлгээ хийх зардлыг төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн улсын төсвөөс санхүүжүүлнэ.

8.4. Үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх ургамлын төрөл, зүйлийн нэр, түүхий эдийн хэмжээ, хугацаа, газрыг шинжлэх ухааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр тогтооно.

## **9 дүгээр зүйл. Ургамлыг нөхөн сэргээх**

9.1. Байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл авсан иргэн аж ахуйн нэгж зөвшөөрлийн дагуу өөрийн хөрөнгөөр биологийн нөхөн сэргээлт хийж тухайн шатны Засаг даргад хүлээлгэн өгнө.

9.2. Тусгай зөвшөөрлийн нөхцөлд заасан хугацаанд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийгээгүй тохиолдолд тухайн шатны Засаг дарга болон мэргэжлийн хяналтын алба хамтран дараагийн жилийн ургамал ашиглах ажлыг эхлүүлэхгүй, эсхүл зөвшөөрлийн хугацааг сунгахгүй байх эрхтэй.

9.3. Байгалийн ургамлын нөөцийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглагч нь арвижуулах, нөхөн сэргээх, арчлах, хамгаалах агротехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх

бөгөөд хэрэгжүүлэх нөхцлийг Байгаль орчин хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан нөхөн сэргээх журмаар зохицуулна.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ БАЙГАЛИЙН УРГАМЛЫГ ЗОХИСТОЙ АШИГЛАХ**

### **10 дугаар зүйл. Байгалийн ургамлыг зохистой ашиглах зориулалт**

10.1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь нэн ховор ургамлыг зөвхөн судалгаа, шинжилгээний зориулалтаар, ховор ургамлыг ахуйн болон судалгаа, шинжилгээний зориулалтаар, элбэг ургамлыг судалгаа, шинжилгээ, ахуйн, үйлдвэрлэлийн зориулалтаар тус тус ашиглаж болно.

10.2. Судалгаа шинжилгээ, ахуйн зориулалтаар түүж бэлтгэх ургамлын дээд хэмжээг шинжлэх ухааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргана.

### **11 дүгээр зүйл. Байгалийн ургамлыг судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах**

11.1. Иргэн, хуулийн этгээдэд нэн ховор, унаган ургамлыг судалгаа, шинжилгээний зориулалтаар түүх зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно.

11.2. Судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах, ашиг олох зорилгоор худалдан борлуулахыг хориглоно.

### **12 дугаар зүйл. Ургамлыг ахуйн зориулалтаар ашиглах**

12.1. Иргэн ховор ургамлыг өөрийн гэр бүлийн хүнсний болон ахуйн хэрэгцээг хангах зорилгоор сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрлөөр ашиглаж болно.

12.2. Ахуйн зориулалтаар авсан зөвшөөрлийг бусдад дамжуулах, зөвшөөрлийг үндэслэн ховор, нэн ховор ургамлыг худалдан борлуулахыг хориглоно.

### **13 дугаар зүйл. Ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах**

13.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага элбэг ургамлыг хүнсний, техникийн болон ургамлын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах зориулалтаар зөвшөөрлийн үндсэн дээр ашиглаж болно.

13.2. Зөвхөн эм бэлтгэн найруулах ажил, үйлчилгээ эрхэлдэг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага ховор ургамлын ашиглалтын нөөцийн 10 хүртэлх хувийг эмийн үйлдвэрлэлийн зориулалтаар зөвшөөрлийн үндсэн дээр ашиглаж болно.

13.3. Тарималжуулсан нөхцөлд нэн ховор, ховор ургамлыг үйлдвэрийн зориулалтаар ашиглаж болно.

13.4. Элбэг ургамлын үндэс, үндэслэг иш, булцууны ашиглалтын нөөцийн 30 ба түүнээс дээш хувийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах тохиолдолд тухайн ургамлыг тарималжуулсан байна.

13.5. Байгалийн ургамлыг тарималжуулах, гадаад улсад гаргахтай холбоотой журмыг байгаль орчин хариуцсан Төрийн захиргааны төв байгууллагаас батална.

#### **14 дүгээр зүйл. Ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хориглох газар**

14.1. Байгаль орчны тэнцлийг хангах ач холбогдол бүхий дараахь газар нутагт ургамлыг нөөцийн хэмжээг үл харгалзан үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хориглоно:

14.1.1. хот, тосгон, бусад суурины ногоон бүс;

14.1.2. гол, горхины эх болон нуур, цөөрмийн эргээс 2 километрийн доторхи газар;

14.1.3. нэн ховор амьтны байршил газар;

14.1.4. баянбүрд;

14.1.5. ургамлын бүрхэвч нь талхлагдсан газар;

14.1.6. элсний нүүлтээс хамгаалах ач холбогдол бүхий газар;

14.1.7. хөрсний элэгдлээс хамгаалах зурвас газар.

14.2. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ зүйлийн 1 дэх хэсгийн 3, 4, 6, 7-д заасан газар, түүний заагийг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн тогтооно.

14.3. Энэ зүйлийн 14.1 дэх хэсгийн 1-4-т заасан газар мал бэлчээж болно.

#### **15 дүгээр зүйл. Ургамлыг хадлан, бэлчээрийн зориулалтаар ашиглах**

15.1. Бэлчээрийн мал аж ахуйн эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага оршин суугаа /оршин байгаа/ сум, дүүргийн газар нутагт мал бэлчээх, хадлан авах зэргээр бэлчээр, хадлангийн газар дахь ургамлыг ашиглахдаа Газрын тухай хуульд заасныг баримтална.

15.2. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал нэн ховор ургамлыг хамгаалах зорилгоор түүний ургадаг газар мал бэлчээх, хадлан авахыг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн хориглоно.

15.3. Ургамлыг нөхөн сэргээх буюу нөхөн сэргэх нөхцөлийг бүрдүүлэх, хамгаалах зорилгоор бэлчээр, хадлангийн газрыг хуваарьтай, даацад нь тохируулж ашиглуулах асуудлыг сум, дүүргийн Засаг дарга шийдвэрлэнэ.

15.4. Бэлчээр, хадлангийн ургамлыг зориулалтын бусаар ашиглах, худалдан борлуулах тохиолдолд байгалийн нөөцийг ашигласны зохих татвар, хураамжийг төлсний үндсэн дээр ашиглана. Бэлчээр, хадлангийн ургамалд зориулалтын бусаар ашиглахтай холбогдсон төлбөр хураамжийг Татварын болон тэмдэгтийн хураамжийн тухай хуулиудад зааснаар тооцож авна.

15.5. Байгалийн ургамлыг хадлангийн зориулалтаар бэлтгэн гадаад улсад гаргахыг хориглоно.

## **16 дугаар зүйл. Ургамлыг ашиглах зөвшөөрөл олгох журам**

16.1. Элбэг ургамлыг үйлдвэрлэлээс бусад зориулалтаар иргэн, хуулийн этгээдэд тухайн шатны Засаг дарга зөвшөөрөл олгоно. Иргэн, хуулийн этгээдэд элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрлийг энэ хуулийн 8.4 дэх заалт болон аймаг, нийслэлийн байгаль орчны албаны дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга зөвшөөрөл олгоно.

16.2. Ховор ургамлыг эм бэлтгэн найруулах ажил, үйлчилгээ эрхэлдэг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага эмийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахдаа ургамлын нөөцийн хэмжээг тогтоолгож, ашиглах ургамлын зүйлийн нэр, түүхий эдийн, ашиглах зориулалт, хэмжээ, хугацааг тусгасан төсөл боловсруулан аймаг, нийслэлийн байгаль орчны албаар батлуулж зөвшөөрлийг Байгаль орчин хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас авна.

16.3. Ургамлыг ашиглах зөвшөөрөл олгох байгууллага нь хүсэлт хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

16.4. Зөвшөөрөл олгохтой холбоотой маргааныг Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

16.5. Ургамлыг ашиглах зөвшөөрлийг эрхийн бичгээр олгоно. Эрхийн бичгийг бусдад шилжүүлэн ашиглуулахыг хориглоно.

16.6. Энэ хуулийн 16.5 дахь хэсэгт заасан эрхийн бичгийн загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

16.7. Эрхийн бичигт ургамлыг түүж бэлтгэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, ургамлын зүйлийн нэр, түүхий эдийн нэр, түүж бэлтгэх хэмжээ, хугацаа, газрыг заана.

16.8. Тухайн нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагч ургамал ашиглах эрхийн бичгийг үндэслэн ургамлыг түүж бэлтгэх газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад зааж өгнө.

## **17 дугаар зүйл. Ургамлыг түүж бэлтгэх, гадаад улсад гаргах**

17.1. Ургамал ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ургамлыг түүж бэлтгэх журам, ашиглахыг зөвшөөрсөн хэмжээ, хугацааг баримтлан түүж бэлтгэнэ.

17.2. Байгалийн ургамал, түүний түүхий эдийг гадаад улсад гаргах зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно.

17.3. Гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгалийн ургамлыг аливаа зориулалтаар түүж бэлтгэхийг хориглоно.

17.4. Нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эдийг судалгаа, шинжилгээнээс бусад зориулалтаар гадаадад гаргахыг хориглоно.

17.5. Байгалийн ургамал түүж бэлтгэх, гадаад улсад гаргах, оруулахтай холбоотой журмыг Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## **18 дугаар зүйл. Байгалийн ургамлын хамтын менежментийн нөхөрлөл байгуулах**

18.1. Нутгийн иргэд байгалийн ургамлыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх зорилгоор нөхөрлөл байгуулж хамтаар ашиглаж болно.

18.2. Нөхөрлөлийн үйл ажиллагааны зарчим, хамрах хүрээ, төлөвлөгөө зэрэг зохион байгуулалтын үндсийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

### **19 дугаар зүйл. Ургамал ашиглагчийн үүрэг**

19.1. Ургамал ашиглагч нь дараахь үүрэгтэй байна:

19.1.1. Байгалийн ургамлын тухай хууль тогтоомжийг биелүүлэх;

19.1.2. ургамлыг түүж бэлтгэх, нөхөн сэргээх журмыг баримтлах;

19.1.3. журам, зөвшөөрөлд заасан хэмжээ, хугацаанд ургамлыг түүж бэлтгэх;

19.1.4. ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэн ургамлыг нөхөн сэргээх буюу нөхөн сэргэх нөхцөлийг бүрдүүлэх;

### **20 дугаар зүйл. Ургамал ашигласны төлбөр**

20.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага төрийн өмчийн газар дээрх байгалийн ургамлыг ашиглахдаа Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 14.4, 14.2 хэсэгт заасны дагуу төлбөр төлнө.

20.2. Байгалийн ургамал ашигласны төлбөрийн дээд, доод хэмжээ, төлбөрөөс чөлөөлөх асуудлыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар зохицуулна.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **21 дугаар зүйл. Мансууруулах бодис бүхий ургамал**

21.1. Мансууруулах бодис агуулсан ургамлын жагсаалтыг байгаль орчны болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

21.2. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мансууруулах бодис агуулсан ургамал ашиглаж эм бэлтгэн найруулах аж ахуйн нэгж, байгууллагад шинжлэх ухааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн зөвшөөрөл олгож тэдгээрийг тусгай бүртгэлд бүртгэнэ.

21.3. Иргэн, түүнчлэн энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад аж ахуйн нэгж, байгууллага мансууруулах бодис бүхий ургамлыг түүх, ашиглах, тарих, худалдан борлуулахыг хориглоно.

21.4. Мансууруулах бодис агуулсан ургамлын тархалтыг багасгаж устгал хийх зардлыг улсын төсвөөс жил бүр санхүүжүүлнэ.

### **22 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**



22.1. Байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж буй иргэн, хуулийн этгээд энэ хууль болон энэ хуультай уялдан гарсан аливаа хэм хэмжээний актыг зөрчвөл зөрчлийн шинж чанараас шалтгаалж эрүүгийн, зөрчлийн хариуцлага хүлээлгэнэ.

22.2. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Зөрчлийн тухай хуульд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

22.3. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

**23 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

23.1. Энэ хуулийг 2018 оны .... дугаар сарын .... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**

---